



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 99125777 Цахим хаяг: Azzayats@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЗЭРЭГ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Б.БАТБИЛЭГ ТАНАА

2024.03.25 № 1/126

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, ОНХС-аас нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон, иргэдийн санал аваагүй дэд хөтөлбөрүүдээс урсгал үйл ажиллагааны шинжтэй тусламж, шагнал урамшуулал, шатахуун, материалын үнэ зэргийн зардал санхүүжүүлсэн, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, татварын орлогын нэр төрлөөр тасарсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 60.3.1. "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 60.3.5. "зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.7.6. "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Спорт заалны барилга 3,299,022.3 мянган төгрөг, Хөл бөмбөгийн талбай 52,000.0 мянган төгрөг, Ган төмөр хашаа 21,000.0 мянган төгрөг, Өвс тэжээлийн агуулах 17,000.0 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Малын тоо толгойн албан татвар 17,966.4 мянга, үйл ажиллагааны орлого 8,842.1 газрын төлбөр 1,075.6 мянга, улсын тэмдэгтийн хураамж 3,421.7, ангын орлого 3,150.0 мянган төгрөгөөр тус тус тасалжээ.

Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 4,642.0 мянга, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 61,932.2 мянга, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 1,770.9 мянга, газрын дуудлага худалдаанаас 6,848.6 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 106.4, хүү торгуулийн орлого 3,321.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангахгүйгээр өвөлжөө хаваржаандаа отрын сууц барьсан нэр бүхий малчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон нь эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд үзүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

“Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон 80.5 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	609,661.30	709,778.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	231,534.2	303,435.0
33	АВЛАГА	279,211.00	283,635.0
35	БАРАА МАТЕРИАЛ	88,916.2	86,068.4
36	НӨӨЦИЙН БАРАА	10,000.0	36,640.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,443,224.5	7,770,238.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,443,224.5	7,770,238.0
39200	Биет хөрөнгө	4,436,532.8	7,763,801.2
39300	Биет бус хөрөнгө	6,691.7	6,436.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,052,885.80	8,480,016.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,941.70	26,903.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,941.70	26,903.7
41300	Өглөг	26941.7	26,903.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,025,944.0	8,453,112.6
51	Засгийн газрын хувь оролцоо	5,025,944.0	8,453,112.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	494,395.7	494,395.7
51200	Хуримтлагдсан үр дүн	4,445,696.0	7,873,144.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,852.3	85,572.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,052,885.80	8,480,016.3

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,410,623.40	5,530,218.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	401,117.4	479,484.3
110	Орлогын албан татвар	248,021.1	307,027.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,021.1	331,352.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-24,325.4
113	Хөрөнгийн албан татвар	59,154.9	21,897.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,941.4	150,559.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,710.0	3,763,063.0
120	Нийтлэг татварын бус орлого	79,710.0	3,763,063.0

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929,796.00	1,287,670.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,800,834.20	2,103,029.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,800,834.20	1,979,380.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,777,789.5	1,959,808.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,713.2	506,299.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,786.9	64,673.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,400.4	78,276.1
2104	Хангамж, бараа материалын зардал	275,792.4	459,877.8
2105	Нормативт зардал	0.0	513.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,477.7	1,435.0
2107	Томилолт, зочны зардал	3,208.0	8,180.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,471.8	352,634.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	715,939.0	487,919.5
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,044.70	19,571.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	123,648.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-390,210.7	3,427,189.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,945,441.0	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,335,651.7	3,427,189.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,746,988.80	2,212,011.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	401,117.4	479,484.3
110	Орлогын албан татвар	248,021.1	307,027.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,021.1	331,352.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-24,325.4
113	Хөрөнгийн албан татвар	59,154.9	21,897.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,941.4	150,559.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,941.3	30,156.9
1181	Газрын төлбөр	8,648.8	10,440.1

1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	81,351.3	109,962.6
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	422,732.4	452,313.9
120	Нийтлэг татварын бус орлого	422,732.4	452,313.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	923,139.00	1,280,213.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,248,186.90	1,525,796.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,248,186.90	1,525,796.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,102.2	1,523,884.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,163.3	665,387.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,680.1	88,086.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	463,442.8	242,663.7
2104	Хангамж, бараа материалын зардал	30,664.2	31,730.8
2105	Нормативт зардал	335.3	501.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,732.1	1,685.6
2107	Томилот, зочны зардал	3,226.1	8,180.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,081.6	406,158.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,776.7	79,490.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,084.70	1,912.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	498,801.9	686,215.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	309,264.1	515,815.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	309,264.1	515,815.0
2200	Дотоод эх үүсвэрээр	309,264.1	515,815.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-309,264.1	-515,815.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100,000.0	-98,500.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	98,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	89,537.8	71,900.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	141,996.4	231,534.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	231,534.2	303,435.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,448,614.9	11,448,614.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-87,019.1	-87,019.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,361,595.8	11,361,595.8
9	Тайлант үеийн үр дүн	-6,335,651.7	-6,335,651.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,025,944.0	5,025,944.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,025,944.0	5,025,944.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-20.5	-20.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,025,923.5	5,025,923.5
19	Тайлант үеийн үр дүн	3,427,189.1	3,427,189.1
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,453,112.6	8,453,112.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,750,048.20	1,548,609.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,085,220.70	1,057,943.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,308.70	1,056,031.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,558.30	507,528.30
210101	Үндсэн цалин	279,219.00	276,312.35
210102	Нэмэгдэл	149,770.10	149,169.76
210104	Урамшуулал	27,057.40	19,522.66
210105	Гэрээт ажлын хөлс	51,511.80	62,523.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,444.60	63,444.60
210201	Тэтгэврийн даатгал	43,142.30	43,142.30
210202	Тэтгэмжийн даатгал	5,075.60	5,075.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,060.50	4,060.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,015.10	1,015.10
210205	Эрүүл мэндийн даатгал	10,151.10	10,151.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,266.30	370,708.14
210301	Гэрэл, цахилгаан	39,407.70	38,453.34
210302	Түлш, халаалт	290,685.90	289,082.10
210303	Цэвэр, бохир ус	43,172.70	43,172.70
2104	Хангамж, бараа материалын зардал	22,099.00	22,098.71
210401	Бичиг хэрэг	2,497.40	2,497.40
210402	Тээвэр, шатахуун	15,979.40	15,979.40

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,622.20	3,621.91
2105	Нормативт зардал	501.10	501.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	501.10	501.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,752.40	7,483.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.60	11.90
210604	Урсгал засвар	7,471.80	7,471.80
2107	Томилолт, зочны зардал	7,092.00	7,051.00
210702	Дотоод албан томилолт	7,092.00	7,051.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,651.80	12,270.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,929.40	11,121.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369.40	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225.00	196.33
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	830.00	830.00
210807	Газрын төлбөр	123.00	122.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,943.20	64,945.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,580.10	63,582.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,363.10	1,363.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,912.00	1,912.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,912.00	1,912.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912.00	1,912.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	564,827,500.00	392,166.14
220001	Барилга байгууламж	370,677,700.00	218,082.65
221001	Их засвар	0.00	1,170.00
222001	Тоног төхөөрөмж	49,100.30	43,696.40
223001	Бусад хөрөнгө	145,049.50	129,217.09
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	98,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.00	98,500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,750,048.20	1,527,074.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,551,137.10	1,461,606.46
320001	Орон нутгийн төсвөөс	1,157,020.50	1,067,489.86
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	394,116.60	394,116.60
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	198,911.10	65,468.04
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	605.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,680.90	64,863.04
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	155,625.20	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	196,293.27
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	174,757.97

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,975.60	232,081.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,975.60	108,433.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,518.40	90,773.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		38,441.40
210301	Гэрэл, цахилгаан		1,000.00
210302	Түлш, халаалт		37,441.40
2104	Хангамж, бараа материалын зардал	1,503.80	1,229.64
210402	Тээвэр, шатахуун	300.0	1,229.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,203.7	
2107	Томилолт, зочны зардал		1,129.14
210702	Дотоод албан томилолт		1,129.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,837.60	35,428.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,837.60	35,428.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,177.00	14,544.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,052.00	14,544.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,125.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,457.20	17,659.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,457.20	17,659.50
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,457.20	17,659.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		123,648.84
2200	Дотоод эх үүсвэрээр		123,648.84
220001	Барилга байгууламж		123,648.84
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		232,081.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,975.60	232,081.92
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,677.60	214,951.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,089.00	200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,209.00	16,930.90

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,586.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 14,914.6 мянган төгрөгийн алдааг залруулан 51,671.7 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж, 16,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өглөө. Үүнд:

- ЗДТГ-т нийлүүлсэн өвс тэжээлийг орлого авахдаа тээврийн хөлсний өртөг шингээлгүйгээр шууд зардалд бүртгэсэн.
- ТТЗ-ийн нэгтгэсэн тайланд урд оны авлага, өглөгийн тоон үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитаар нийт 51,671.7 мянган төгрөгийн 4 заалт зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Сумын ОНХС-аас өвөлжөө хаваржаандаа отрын сууц барьсан малчдад нэг удаагийн буцалтгүй тусламж 8 хүнд тус бүр 2,000.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 60.3.1. "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 60.3.5. "зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.7.6. "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3.2 Зөвлөмж

3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас 2012-2017 онуудад олгосон 7 иргэнтэй холбоотой 44,411.6 мянган төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, зээл зээлийн хүүгийн төлбөр төлөгдөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтууд болон сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээл, зээлийн хүү, алдангийг төлүүлэх талаар үе шаттай арга хэмжээ хэрэгжүүлэн сум хөгжүүлэх санд төвлөрүүлэх

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй дэд хөтөлбөрүүд баталж зарим урсгал үйл ажиллагааны шинжтэй тусламж, шагнал урамшуулал, шатахуун, материалын үнэ зэргийн зардал санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4. "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.4. "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Өгсөн зөвлөмж: Илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх. Хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тооцон ажиллах.

3.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.2.2. "Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих"; гэж заасантай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.

3.2.4 ОНӨААТҮГ-ын хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тээлийн илч ОНӨААТҮГ бие даасан хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн ч 2020 оны шийдвэртэй газрыг бүртгэл тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тээлийн илч ОНӨААТҮГ-ын бүх хөрөнгийг тус байгууллагын өөрийн эзэмшил ашиглалт, бүртгэлд бүртгүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ТТЗ	Санхүүгийн байдлын тайлангийн тоон үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн	1	14,914.6			1	14,914.6	1	14,914.6				
	ДҮН	1	14,914.6			1	14,914.6	1	14,914.6				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хоршоо хөгжүүлэх сан	Сум хөгжүүлэх сангаас 2012-2017 онуудад олгосон зээл зээлийн хүүг төлүүлэх арга хэмжээ аваагүй	1	44,411.6					1	44,411.6		
Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй дэд хөтөлбөрүүд баталж зарим урсгал үйл ажиллагааны шинжтэй зардал санхүүжүүлсэн.	1	7,260.1					1	7,260.1		
Орон нутгийн хөгжлийн сан	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй	1						1			
Орон нутгийн хөгжлийн сан	Малчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон	1	16,000.0			1	16,000.0				
ТТЗ	Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэнч 2020 оны шийдвэртэй газрыг бүртгэл тайланд тусгаагүй	1						1			
		5	67,671.7			1	16,000.0	4	51,671.7		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	Нийт	1	1				1		

[Type here]

